

ГИХГ-ЫН БУЯНТ-УХАА ДАХЬ ГАЗРЫН 2018 ОНЫ ЗУРГААДУГААР САРД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ  
/2018.05.26 - 2018.06.15/

2018 оны 06 дугаар сарын 18

Буянт-Ухаа

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Биелэлт
1	2	3	4	5
1.		Олон улсын стандартад нийцсэн агаарын замын боомт нээгдэх үед нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг шат дараатай зохион байгуулах.	Батлагдсан төлөвлөгөө-ний хүрээнд шинэ нисэх буудлын АӨЗ-ны алба-наас зохион байгуулах сургалтад тус газрын сургагч 3 ажилтанг хамруулах. Хөшигийн хөндийн нисэх буудал дахь Хилийн хяналт шалгалтын баталгаажсан бүс, хяналт шалгалтын ерөнхий зарчмыг танилцуулах сургалтыг тус газрын албан хаагчдад зохион байгуулах.	Буянт-Ухаа дахь Чингис хаан ОУ-ын нисэх буудлын үйл ажиллагааг Хөшигийн хөндийн шинэ нисэх буудалд нүүлгэн шилжүүлэх ажиллагааны төлөвлөгөөний дагуу АӨЗ-ны албатай хамтран 2018.06.13-ны өдөр тус газрын 3 албан хаагч Хөшигийн хөндийн нисэх буудал дахь Хилийн хяналт шалгалтын баталгаажсан бүс, хяналт шалгалтын ерөнхий зарчим болон тус газар байрлахаар төлөвлөсөн ирэгч, явагчийн танхим дахь өрөөтэй танилцав.
2.	Газрын үйл ажиллагааны чиглэлээр	Төслийн хэмжээнд бэлтгэсэн хилийн боомтын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах үг хэллэгийг агуулсан англи-монгол хэлний ярианы дэвтрийг хэвлүүлэхэд бэлэн болгох.	Төслийн хэмжээнд бэлтгэсэн англи-монгол хэлний ярианы дэвтрийг холбогдох албан тушаалтнаар хянуулж, өгсөн чиглэлийн дагуу засварыг хийн хэвлүүлэхэд бэлэн болгосон байна.	Байгууллагын чиг үүргийг “Чингис хаан” ОУ-ын нисэх буудалд хэрэгжүүлэхэд тус газрын албан хаагчид өдөр тутам гадаадын иргэдтэй харилцдаг тул боомтод өдөр тутам хэрэглэгддэг 200 орчим үг, өгүүлбэр оруулсан англи-монгол хэлний ярианы дэвтрийн төслийг тус газрын даргад танилцуулж өгсөн чиглэлийн дагуу засвар оруулан хэвлүүлэхэд бэлэн болгов.
3.		Бүсийн онцлогт тохирсон ялгах тэмдгийн загвар, ашиглалтын талаарх санал боловсруулан байгууллагын удирдлагад танилцуулахаар хүргүүлэх.	Саналаа албан бичиг болон холбогдох материалын хамт ГИХГ-ын даргад танилцуулсан байна.	Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.11-д “Төв, орон нутагт Байгууллагын даргын тушаалаар баталсан бэлгэ тэмдгийг хэрэглэнэ” гэж заасны дагуу тус газар нь өөрийн бэлгэ тэмдгийн загварыг гарган байгууллагын даргаар батлуулахаар төвд 2018.06.07-ны өдөр 12/63 дугаар албан бичгээр хүргүүлэв.

1	2	3	4	5
4.		Буянт-Ухаа дахь газрын үйл ажиллагааны талаарх статистик мэдээ агуулсан эмхэтгэлийн төсөл бэлтгэх.	2016, 2017 оны статистик мэдээ агуулсан эмхэтгэлийг төслийн хэмжээнд боловсруулсан байна.	<p>Буянт-Ухаа дахь газар нь дотоод үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор тус газрын үйл ажиллагааны талаарх статистик мэдээ агуулсан эмхэтгэлийн төслийг бэлтгэв.</p> <p>Тус эмхэтгэлийн төсөлд Буянт-Ухаа боомтод олгосон виз, түр ирэгчийн бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, захиргааны зөрчил, албадан гаргасан гадаадын иргэн, хил дээрээс буцаасан иргэний талаарх 2016, 2017, 2018 /2018 оны тоон мэдээг эхний хагас жилийн байдлаар тусгасан/ оны тоон мэдээг он, улс, зөрчлийн төрөл зэргээр ангилсан болно.</p> <p>Тус газрын даргаас өгсөн чиглэлийн дагуу хүний нөөцтэй холбоотой тоон мэдээллийг нэмж оруулахаар ажиллаж байна.</p>
5.	Дээд шатны байгууллагыг мэдээллээр хангах чиглэлээр	Газрын үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэж Гадаадын иргэн, харьяатын газрын холбогдох нэгжид хугацаанд нь хүргүүлэх.	Захиргаа, Төв аймаг дахь төлөөлөл, боомтод ажиллаж буй 4 ээлжээс хийсэн ажлын тайлан, төлөвлөгөөний биелэлт, хийх ажлын төлөвлөгөөг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасан хугацаанд авч, нэгтгэн ГИХГ-ын Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Тус газрын захиргаа болон Буянт-Ухаа боомтод ажиллаж буй 1, 2, 3, 4 дүгээр ээлжээс 2018 оны 07-р сард хийх ажлын саналыг авч нэгтгэн газрын даргаар батлуулан 2018.06.13-ны өдөр, 06-р сард хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг гаргаж мөн сарын 16-ны өдөр, зургаадугаар сард хийж гүйцэтгэсэн ажлын тайланг төвөөс өгсөн үүргийн дагуу энэ сарын 15-ны өдрөөр тасалбар болгон авч нэгтгэн ГИХГ-ын Боомт, орон нутгийн хэлтэст 2018.06.16-ны өдөр хүргүүлэв.
6.		Байгууллагын инфографик мэдээнд тусгах статистик тоог гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Тоон мэдээг 2017 онтой харьцуулан гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	ГИХГ-аас гаргадаг инфографик мэдээнд тусгах тус газрын 2018.06-р сарын статистик тоог 2017 оны мөн үетэй харьцуулж БОНХ-т 2018.06.15-ны өдөр цахимаар хүргүүлэв.

1	2	3	4	5
7.		Байгууллагын даргын батлан гаргасан албан даалгаврын биелэлтийг гаргаж холбогдох нэгжид хүргүүлэх ажлыг зохион байгуулах.	Биелэлтийг үнэн зөв гаргаж Боомт, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн байна.	Байгууллагын даргын батлан гаргасан 2017 оны 03, 05, 06, 2018 оны 02, 04, 05 дугаар албан даалгаврын биелэлтийг гаргаж ГИХГ-ын Боомт, орон нутгийн хэлтэст 2018 оны 05 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн. Түүнчлэн 2018 оны 01, 02, 03, 04, 05, 06, 07, 09 дүгээр албан даалгаврын биелэлтийг гаргаж ГИХГ-ын Боомт, орон нутгийн хэлтэст 2018 оны 06 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлсэн.
8.		Гадаадын иргэнд виз олгох, визний шилжүүлэг хийх, бүртгэл, хасалтын үйлчилгээ үзүүлэх.	Төрийн үйлчилгээг гадаадын иргэнд түргэн шуурхай үзүүлсэн байна.	Нийт 66 орны 447 гадаадын иргэнд зохих ангилал, зориулалтын визийг олгосон ба визийн шилжүүлэг 18 хийсэн байна. Үүнд, нэг удаагийн орох 399, хоёр удаагийн орох 0, олон удаагийн орох 11, нэг удаагийн гарах-орох 8, хоёр удаагийн гарах-орох 0, олон удаагийн гарах-орох 9, дамжин өнгөрөх 2, түр ирэгчийн бүртгэл 32, хасалт 35, оршин суух зөвшөөрлийн хасалт 6, визийн засвар 29, хүчингүй болгосон виз 1 байна.
9.	Виз, бүртгэлийн чиглэлээр	Монгол Улсын визгүй, хориг арга хэмжээ авагдсан гадаадын иргэнийг буцаах арга хэмжээ авч ажиллах.	Гадаадын иргэний мэдээллийг “ISM” систем дээр шалгаж визгүй, хориг арга хэмжээтэй гадаадын иргэнийг хил нэвтрүүлэлгүй буцаасан байна.	Гадаадын иргэний мэдээллийг “ISM” систем дээр шалгаж Монгол Улсын виз, визийн зөвшөөрөлгүй, ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулах зэрэг үндэслэлээр Афганистан 1, Филиппин 1, БНСУ-ын 3, Иран 1, нийт 6 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан ба гарах визгүй, аж ахуйн нэгжийн албан бичиггүй зэрэг үндэслэлээр Филиппин 1, Япон 1, нийт 2 гадаадын иргэнийг Монгол Улсын хилээр гаргаагүй болно. Харин шүүх, прокурор, ШШГЕГ-ын хүсэлтийн дагуу Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн байхгүй байна.

1	2	3	4	5
10.	Хяналт шалгалтын чиглэлээр	Барилга, зам гүүр үйлдвэрийн барилга байгууламж, уул уурхай болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгуулагад хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх.	Удирдамж батлуулан хяналт шалгалтыг зохион байгуулж, дүнг Буянт-Ухаа дахь газрын даргад танилцуулсан байна.	ГИХГ-ын Буянт-Ухаа дахь газрын даргын баталсан БУ2018-06 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2018.06.04-ний өдөр Төв аймгийн Алтанбулаг сумын 2 дугаар баг Бөхөг гэх газарт байрлах 2 ААН-д хийв. Шалгалтаар 28 гадаадын иргэн хамрагдаж, зөрчил илрээгүй бөгөөд дүнг тус газрын даргад 2018.06.06-ны өдөр танилцуулав. Харин БУ2018-07 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2018.06.12-ны өдөр Төв аймгийн Баянцогт сумын Гуна багт үйл ажиллагаа явуулдаг “Лакибридж” ХХК-ийн ногооны хүлэмжинд явуулав. Шалгалтаар 6 гадаадын иргэн хамрагдаж паспорт, паспортыг орлох баримт бичиг, оршин суух үнэмлэхээ биедээ авч яваагүй БНХАУ-ын 1 иргэнд торгуулийн арга хэмжээ авч, дүнг тус газрын даргад 2018.06.13-ны өдөр илтгэх хуудсаар танилцуулав.
11.		Зөрчлийн тухай хуулийн дагуу ГИЭЗБТХууль зөрчсөн гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллах.	Зөрчил гаргасан гадаадын иргэн, ААН, байгууллагын зөрчлийг шийдвэрлэж, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн, визийн хугацаа хэт-рүүлсэн, оршин суух журам зөрч-сөн зэрэг үндэслэлээр 15 гадаа-дын иргэнд 2`700`000 төгрөг, 1 ААН-д /хамрагдсан гадаадын ир-гэн 1/ 20`000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгөв.
12.		Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг илрүүлсэн тохиолдолд Монгол Улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулах.	Холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэл хийсэн байна.	Төлөвлөгөөт хугацаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу албадан гаргагдах гадаадын иргэн илрээгүй тул тус газраас албадан гаргасан гадаадын иргэн байхгүй болно.

1	2	3	4	5
13.		Визгүй зорчдог болон хоригт багтсан орны иргэдэд хил дээр тавих хяналтыг сайжруулж ажиллах.	Хил дээр тавих хяналт сайжирсан байна.	Монгол Улсад визгүй зорчигч болон хоригт багтсан гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 9 орны 106 иргэнтэй ярилцлага хийж бичиг баримтыг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөлсөн болно. Үүнд: Украин 14, Киргиз 13, Филиппин 50, Казакстан 20, Израиль 3, БНЭУ-1, Тайланд 1, БНСВУ 3, БНХАУ 1.
14.		Нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх арга зүйн сургалт зохион байгуулах.	Хяналтын улсын байцаагчид бие хамгаалах урлагт суралцаж, аюулгүй байдал хангагдсан байна.	Тус газрын даргын баталсан 2018 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтэстэй хамтран тус газрын хяналтын улсын байцаагч нарт нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх арга зүйн сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Сургагч багш болох Иргэний агаарын тээвэр дэх Цагдаагийн хэлтсийн албан хаагчийн ажлын ачааллаас шалтгаалан уг сургалтыг энэ сард зохион байгуулах боломжгүй болсон тул ирэх сард зохион байгуулахаар харилцан тохиролцож, холбогдох арга хэмжээг авж ажиллаж байна.
15.	Хүний нөөц, сургалтын чиглэлээр	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх I шатны төлөвлөгөөний иргэдийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг суртачилах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн талаар ойлголттой болсон байна.	“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” чиглэлээр 2018.06.11-ний өдөр тус газрын нийт 23 албан хаагчдад сургалт зохион байгуулж Нийслэлийн цагдаагийн газрын Хар тамхитай тэмцэх хэлтсийн 2 албан хаагч ирж мэдээлэл хийв. Тус сургалтаар албан хаагчдад мансууруулах бодисын хууль бус эргэлтийн нөхцөл байдал, шинээр аюул, заналхийлэл учруулж буй шинэ төрлийн сэтгэцэд нөлөөт бодис, урьдчилан сэргийлэх арга замын талаар хичээл орж харилцан ярилцав.

1	2	3	4	5
16.		Хүний нөөцтэй холбоотой судалгааг гаргах.	Газрын дотоод үйл ажиллагаанд ашиглах албан хаагчдын талаарх холбогдох судалгааг гаргаж Төрийн албаны зөвлөлийн цахим програмд баяжилт хийсэн байна.	Тус газарт шинээр томилогдон ирсэн 1 албан хаагчийн талаарх мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн цахим програмд шивж оруулсан. Түүнчлэн тус програмд шинээр зэрэг дэв цонх нээгдсэнтэй холбогдуулан төрийн захиргааны нийт 21 албан хаагчдын мэдээллийг оруулав. Үүнээс гадна сахилгын шийтгэлтэй албан хаагчдын талаарх судалгааг шинэчилэн гаргалаа.
17.	Санхүү, хангамжийн чиглэлээр	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах.	Төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлэн ажилласан байна.	Батлагдсан төсвийг зохих зардлын дагуу зарцуулан өр, авлагагүй ажилласан. Батлагдсан төсөв болох өссөн дүнгээр 227,705,600 төгрөгийн санхүүжилт орсноор цалин хөлсөнд 138,535,612 төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 17,397,177 төгрөг, ХУД-т цалин хөлснөөс суутгасан ашгийн татварт 11,410,476 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 10,459,227 төгрөг зарцуулсан.
18.		Тус газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн 2018 оны эхний хагас жилийн тооллогыг зохион байгуулах.	Тооллогыг зохион байгуулж, дүнг тус газрын даргад танилцуулсан байна.	Тус газрын даргын баталсан 2018.06.04-ний өдрийн А/13 дугаар тушаалын дагуу Буянт-Ухаа дахь газрын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн 2018 оны эхний хагас жилийн тооллогыг 2018.06.04-өөс 08-ны өдрүүдэд явуулж бүртгэл хөтөлсөн бөгөөд дүнг тус газрын даргад мөн сарын 12-ны өдөр танилцуулсан.
19.		Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайланг үнэн зөв гарган тогтоосон хугацаанд тайлагнах.	НД-ын шимтгэлийн тайланг дараа сарын 5, төсвийн гүйцэтгэлийн тайланг дараа сарын 2-ны өдрийн дотор гаргаж төсөв санхүүгийн үр ашигтай тогтолцоо бүрдсэн байна.	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2018.06.02-ны дотор гарган ХУД-ийн Төрийн сангаар баталгаажуулан ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн. Мэдээгээр 227,705,600 төгрөгийн урсгал санхүүжилт орсоноос нийт зарлага 184,716,490 төгрөгийн ажил үйлчилгээ явуулж өглөг авлагагүй ажилласан. НДШ-ийн тайланг гарган 2018.06.05-ны дотор НДХ-т хүргүүлэн тооцоо нийлэв.

1	2	3	4	5
20.		Үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог хугацаанд нь гаргаж, бүртгэл хөтлөн ажиллах.	Бүртгэл тооцоо хугацаандаа чанартай хийгдсэн байна.	Албан хаагчдад үнэт цаас болох визийн хуудас 300 ширхэгийг шаардах хуудасны дагуу олгосон. Түүнчлэн авто машины ашиглалт болон шатах тослох материалын тооцоог жолооч дэвтэрт бичилтийг хийн бүртгэл хөтлөв.
21.		Төсвийн хүрээнд худалдан авалт хийх, албан хаагчдын ажиллах нөхцлөөр хангаж ажиллах.	Шаардлагатай бараа материалын худалдан авалт хийж шаардах хуудасны дагуу бараа материалыг тухай бүр нь гаргаж өгсөн байна.	Хангамж, бараа материалын зардалд өссөн дүнгээр 10,459,227 төгрөгийн худалдан авалт хийж, албан хаагчдыг шаардлагатай бараа материалаар хангаж ажилласан.
22.		Албан хэрэгцээнд ашиглаж буй суурин утас, шуудангийн болон боомтод байрлах албан хаагчдын ажлын байрны түрээсийн төлбөр тооцоог нэхэмжлэхийн дагуу тухай бүр шийдвэрлэх.	Нэхэмжлэхийн дагуу тухайн байгууллагын холбогдох дансруу шилжүүлэн өглөг авлагагүй ажиллана.	Албан хэрэгцээнд ашиглаж байгаа суурин утас болон интернетийн төлбөрт 1,371,825 төгрөг, байрны түрээс 6,980,000 төгрөг харилцагч байгууллагын нэхэмжлэхийн дагуу холбогдох данс руу шилжүүлсэн.
23.		Татварын улсын тэмдэгтийн хураамж, хүү, торгуулийн тайланг гаргаж тооцоо нийлэх.	Хяналтын улсын байцаагч нараас тайланг авч тулган, сар бүрийн 5-ны дотор төвд хүргүүлсэн байх.	Энэ оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүү торгууль өссөн дүнгээр 10,400,000 төгрөгийг Төв аймгийн төрийн санд, визийн тэмдэгтийн хураамж 151,062,440 төгрөг, визийн хуудас 22,389,540 төгрөгөөр тайлан нэгтгэн Хяналтын улсын байцаагч нартай тооцоо нийлэн ГИХГ-ын Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.
24.		Бараа материалын тайлан, кассын тайланг тухай бүр гаргах.	Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажилласан байна.	Бараа материалын болон шатахууны тайланг гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн хуулийн дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн гаргасан ба хянуулж баталгаажуулсан. Хангамж, бараа материалын зардалд 10,459,227 төгрөгийн худалдан авалт хийж, албан хаагчдыг шаардлагатай бараа материалаар хангаж ажилласан.

1	2	3	4	5
25.		Газрын албан хаагчдын нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийх.	Албан хаагчдын НДД, ЭМД-ын дэвтэрт бичилт хийж нийгмийн даатгалын байцаагчаар НДД-ийг баталгаажуулсан байна.	Тус газрын нийт 26 албан хаагч, хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагчийн нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын дэвтэрт холбогдох бичилтийг хийж Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээр баталгаажуулав.
26.	Өргөдөл, гомдлын чиглэлээр	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өргөдөл, гомдол гаргах бүрт бүртгэл хөтлөн, холбогдох албан хаагчид хүргүүлж, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлэх.	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан хаагчаас гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуульд заасан хугацаанд шийдвэрлүүлсэн байна.	Буянт-Ухаа дахь газрын албан хаагчаас ирсэн 1 өргөдлийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, уг өргөдөлд Бүртгэл-хяналтын карт хөтөлж, газрын даргад танилцуулан шийдвэрлүүлж, холбогдох албан хаагчид хариуг хүргүүлж ажиллалаа. Тайлант хугацаанд тус газарт ирсэн гомдол байхгүй болно.
27.	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагааны чиглэлээр	Газарт ирсэн, явсан албан бичгийн бүртгэл хөтөлж, хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллах.	Ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хөтөлжсөн хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу тус газарт ирсэн нийт 11 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, Бүртгэл-хяналтын карт хөтлөн, газрын даргад танилцуулан цохолт хийлгэж, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин ажиллалаа. Хариутай 4 албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажилласан ба 9 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэв.
28.		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэх.	Ирсэн, явсан албан бичиг, тус газрын даргын баталсан тушаалыг сканердаж цахим архив үүсгэсэн байна.	Тус газрын цаасан суурьтай баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Буянт-Ухаа дахь газрын даргын батлан гаргасан 2 тушаал, тус газарт ирсэн 11, явсан 9 албан бичиг, тус газрын энэ сарын төлөвлөгөө, түүний биелэлт, тайланг сканердаж цахим хэлбэрт шилжүүлсэн.
29.	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах.	Ирсэн дуудлагын дагуу засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаанд оруулсан байна.	Дотоод сүлжээ, техник хэрэгслийн 8 дуудлага хүлээн авч засварлан хэвийн ажиллагаанд оруулсан. Түүнчлэн "ISM" сүлжээ 2018.06.05-ны өдөр тасарсантай холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мөн сарын 06-ны өдөр илтгэх хуудсаар төвд хүргүүлсэн.



1	2	3	4	5
30.		Тус газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг бэлтгэн байгууллагын цахим хуудсанд байршуулах ажлыг зохион байгуулах.	Тус газрын сарын төлөвлөгөө, биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.	Тус газрын энэ сарын төлөвлөгөө, биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулахад бэлэн болгосон боловч Мэдээллийн технологийн хэлтсээс тус цахим хуудас шинэчлэгдэж байгаа тул мэдээ нэмж тусгах шаардлагагүй гэсэн чиглэл өгсөн бөгөөд шинэчлэгдсэний дараа дээрх мэдээг нөхөн байршуулахаар болов.
31.	Олон нийттэй харилцан чиглэлээр	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг тухай бүр оруулж, иргэд хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлэх.	Шилэн дансны хуулийн хэрэгжилт болон төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, мэдээг үнэн зөв оруулсан байна.	Төсвийн зарцуулалтын талаар Shilendans.gov.mn сайтад мэдээллийг шивж оруулсан. Тухайлбал, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл зэргийг байршуулж олон нийтийг мэдээллээр хангаж ажиллав.
32.	Төв аймаг дахь цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр	Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэний мэдээллийг сүлжээнээс шүүж цагдаагийн хэсгийн байцаагч нарт хүргүүлэх, харилцан мэдээлэл солилцох	Холбогдох сүлжээнээс шүүлт хийж, харилцан үнэн, зөв мэдээллээр хангасан байна.	Тус газар Төв аймгийн нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэний мэдээллийг “ISM” сүлжээнээс шүүж 2018.06.07-ний өдөр Төв аймгийн цагдаагийн хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Ж.Батмөнхөд хүргүүлсэн болно.

1	2	3	4	5
		Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулсан болон албадан гаргаж, орохыг хориглосон гадаадын иргэний талаарх мэдээлэл	Мэдээлэл, судалгааг харилцан солилцсон байна.	Тус газар Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу захиргааны шийтгэл ногдуулсан болон албадан гаргаж, орохыг хориглосон гадаадын иргэний талаарх мэдээллийг "ISM" сүлжээнээс шүүж 2018.06.07-ний өдөр Төв аймгийн цагдаагийн хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч Ж.Батмөнхөд хүргүүлсэн болно.

Төлөвлөсөн: 32  
Биелсэн: 30  
Хагас биелсэн: 2  
Биелээгүй: 0  
Хувь: 97